

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	11
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18
4.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.7	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татварын Тухай Хууль



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ М.БЯМБАСҮРЭН ТАНАА

2019.02.25 № 06/322
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

ОРШИЛ

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал М.Бямбасүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө биелүүлэх зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 6-ны өдрөөс 2019 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК-ийн аудитор Н.Уранчимэг, аудиторын туслах Д.Должидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд ургамал хамгааллын салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, тухайн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилго тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэл:

Ургамал хамгааллын тухай хууль болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2015 оны А/337 тоот “Үйл ажиллагааны чиглэл тогтоох тухай” тушаалаар батлагдсан Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Ургамлын өвчин, хортон шавьж, мэрэгч амьтан, хог ургамлын зүйлийн тархалт, хор хөнөөлийг тогтоох, тэдгээрийн био-экологийн онцлогийг судлах, байгаль орчинд халгүй тэмцэх арга боловсруулахад чиглэдэг байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль
- Инновацийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль

Тайлант хугацаанд тус байгууллагын мөрдөж байгаа хууль эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/40 дүгээр тушаалаар батлан мөрдүүлж байгаа уг бодлого нь тухайн байгууллагын онцлог буюу хэд хэдэн тайлангийн хугацаанд хамрагдах эрдэм шинжилгээний ажлын зардал болон түүнтэй холбоотой санхүүжилтийн орлогыг хэрхэн яаж тусгах талаар тодорхой тусгаагүй байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програмыг ашигладаг байна.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад тус

байгууллагын дотоод хяналтыг Хүний нөөцийн мэргэжилтэнд хавсран гүйцэтгүүлэх шийдвэр гарсан боловч тайлант онд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт орлогын 1 хувиар сонгов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгосон ба гүйцэтгэлийн үе шатанд нэмэлт санхүүжилтийн орлого нэмэгдсэн тул нийт орлогыг сонгох нь зүйтэй гэж үзлээ.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 766,340.5 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,663.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг шинээр илрүүлж аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

				/мянган төгрөг/
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	1,941.3	
	Дүн	2	1,941.3	

2.1.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчил байхгүй болно.

ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц асуудлын хувьд эрдэм шинжилгээний ажлын 2016 оноос эхэлсэн, үргэлжлэн хэрэгжих төслийн санхүүжилтийн тайлант жилийн зардлыг урьдчилж төлсөн зардал дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнасан байна. Шинжлэх ухаан технологийн сангаас ирсэн албан тоотод Эрдэм шинжилгээний төслийн санхүүжилтийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэх тухай шийдвэрийг үндэслэн бүртгэж байгаа нь орлого, зардлын уялдаатай, нягтлан бодох бүртгэлийн жинхэнэ хэрэгжилтийн зарчимтай нийцэхгүй байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Дараагийн аудитаар эрдэм шинжилгээний зардлыг нарийвчлан авч үзэх шаардлагатай байна.

2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 4 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 650,069.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 646,886.5 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна. Тайлант жилд нийт зардлыг 1,938.5 мянган төгрөгөөр хэмнэсэн ба эдийн засгийн ангиллаар авч үзэхэд төсвийн зардал хэтрээгүй байна.

Үндсэн үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөө 3,150.0 мянган төгрөг батлагдсанаас 1,900.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь дээд шатны төсвийн захирагчаас орлогын төлөвлөгөөг тус байгууллагын үйл ажиллагааны орлого олох боломжтой уялдуулж батлаагүй байна.

Шилэн дансны мэдээлэл

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны цахим хуудсанд төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 20 мэдээлэл оруулахаас 18 мэдээлэл оруулсан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөн бөгөөд 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Өмнөх оны аудитаар орлогын төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотой зөвлөмж өгөгдсөн. Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 60.6 хувийн биелэлттэй байгаа нь тус байгууллагын лабораторийн итгэмжлэлийн хугацаа сунгагдаагүйгээс шинжилгээний орлого биелээгүйтэй холбоотой байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар

1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөгөөр 3,150.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,900.0 мянган төгрөг төвлөрүүлсэн нь орлогын төлөвлөгөөг 1,250.0 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Энэ нь төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “улс орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Эрсдэл

Санхүүгийн тайлангийн “хэмжилт”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах.

4. Тухайн байгууллагын санал: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Цалингаас тооцсон ХХОАТ-н талаар

1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд ажиллагсдад олгохоор тооцсон цалингаас ХХОАТ-ыг тооцохдоо татварын хөнгөлөлтийг илүү, дутуу тооцсоноос 691.0 мянган төгрөгийн зөрүү үүсч байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараахь албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Эрсдэл

Санхүүгийн тайлангийн “хэмжилт”, “эрх ба үүрэг”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдэл зөрчигдөх.

3. Зөвлөмж: Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

4. Тухайн байгууллагын санал: Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4.Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>246,099,814.22</u>	<u>414,852,278.72</u>
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Банкинд байгаа бэлэн мөнгө		
Төгрөг		
Төрийн сангийн харилцах		
УРЬДЧИЛГАА	<u>131,843,200.00</u>	<u>249,906,300.00</u>
Урьдчилж гарсан зардал	131,843,200.00	249,906,300.00
БАРАА МАТЕРИАЛ	<u>114,256,614.22</u>	<u>164,945,978.72</u>
Хангамжийн материал	114,256,614.22	164,945,978.72
Бичиг хэргийн материал	9,862,000.00	5,391,520.00
Аж ахуйн материал	90,734,414.22	145,759,188.72
Сэлбэг хэрэгсэл	13,660,200.00	13,795,270.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>560,542,710.61</u>	<u>867,416,681.30</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	560,542,710.61	867,416,681.30
Биет хөрөнгө	560,080,710.53	543,595,721.18
Барилга, байгууламж, орон сууц	32,020,000.00	86,949,692.00
Хуримтлагдсан элэгдэл	-16,378,777.80	-7,192,333.25
Авто-тээврийн хэрэгсэл	47,003,287.69	47,003,287.69
Хуримтлагдсан элэгдэл	-47,003,287.69	-47,003,287.69
Машин тоног төхөөрөмж (компьютер)	823,555,724.53	830,545,124.53
Хуримтлагдсан элэгдэл	-301,299,030.38	-388,583,547.38
Тавилга, аж ахуйн эд хогшил	121,550,472.33	124,950,472.33
Хуримтлагдсан элэгдэл	-101,718,895.39	-105,424,904.29
Ном	2,351,217.24	2,351,217.24
Биет бус хөрөнгө	<u>462,000.08</u>	<u>323,820,960.12</u>
Програм хангамж	1,770,000.00	1,770,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-1,307,999.92	-1,461,999.88
Бусад биет бус хөрөнгө		323,512,960.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>806,642,524.83</u>	<u>1,282,268,960.02</u>
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>806,642,524.83</u>	<u>1,282,268,960.02</u>
Засгийн газрын хувь оролцоо	806,642,524.83	1,282,268,960.02
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	240,151,898.93	563,664,858.93
Өмч: - төрийн	240,151,898.93	563,664,858.93
Хуримтлагдсан үр дүн	552,972,469.59	639,200,086.03
Өмнөх үеийн үр дүн	552,972,469.59	552,972,469.59
Тайлант үеийн үр дүн	00.00	86,227,616.44
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,518,156.31	79,404,015.06
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>806,642,524.83</u>	<u>1,282,268,960.02</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	937,670,055.00	766,340,500.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,900,000.00
Нийтлэг татварын бус орлого		1,900,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого		1,900,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт		1,900,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	937,670,055.00	764,440,500.00
Улсын төвлөрсөн төсвөөс	647,652,400.00	646,919,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	647,652,400.00	646,919,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	290,017,655.00	117,521,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		24,540,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		92,981,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	290,017,655.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	838,380,402.42	680,112,883.56
УРСГАЛ ЗАРДАЛ	838,380,402.42	680,112,883.56
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	824,880,402.42	678,174,352.56
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,824,866.00	446,377,218.00
Үндсэн цалин	375,616,866.00	358,204,210.00
Нэмэгдэл	54,742,800.00	67,095,800.00
Унаа хоолны хөнгөлөлт	16,465,200.00	16,465,200.00
Урамшуулал		4,612,008.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,896,200.00	53,671,461.00
Тэтгэврийн даатгал	33,024,854.54	45,182,228.00
Тэтгэмжийн даатгал	4,717,836.35	2,124,000.00
ҮОМШӨ-ний даатгал	9,435,672.72	1,694,900.00
Ажилгүйдлийн даатгал	943,567.28	423,900.00
Эрүүл мэндийн даатгал	3,774,269.11	4,246,433.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	606,961.00	737,100.00
Гэрэл цахилгааны зардал	606,961.00	737,100.00
Хангамж, бараа материалын зардал	18,087,627.00	6,965,693.00
Бичиг хэрэг	8,072,000.00	4,099,110.00
Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,585,827.00	1,440,083.00
Ном, хэвлэл	7,059,800.00	142,500.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	84,000.00
Норматив зардал	400,000.00	7,546,170.00
Эм		7,000,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	400,000.00	546,170.00

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эд хогшил, урсгал засварын зардал	14,900,000.00	13,963,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	14,900,000.00	13,963,000.00
Томилолт, зочны зардал	85,960,000.00	32,573,620.00
Гадаад албан томилолт		
Дотоод албан томилолт	85,960,000.00	32,573,620.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	98,595,496.00	23,425,842.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,628,630.00	20,405,252.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	71,280.00	71,280.00
Тээврийн хэрэгслийн татвар	160,570.00	160,500.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246,400.00	246,400.00
Газрын төлбөр	466,616.00	520,410.00
Бараа үйлчилгээний бусад зардал	107,609,252.42	92,914,248.06
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,609,252.42	92,914,248.06
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,500,000.00	1,938,531.00
Бусад урсгал шилжүүлэг	13,500,000.00	
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	13,500,000.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,938,531.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,938,531.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	99,289,652.58	86,227,616.44
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	99,289,652.58	86,227,616.44

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

		/төгрөгөөр/
Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	944,746,748.00	766,340,500.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		1,900,000.00
Нийтлэг татварын бус орлого		1,900,000.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого		1,900,000.00
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,900,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	944,746,748.00	764,440,500.00
Улсын төвлөрсөн төсвөөс	647,652,400.00	646,919,500.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	647,652,400.00	646,919,500.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	290,017,655.00	117,521,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллага		24,540,000.00
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		92,981,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	290,017,655.00	
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,076,693.00	
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,076,693.00	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	893,081,527.00	755,951,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	893,081,527.00	755,951,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	879,581,527.00	754,012,569.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,901,559.00	446,377,218.00
Үндсэн цалин	382,693,559.00	358,204,210.00
Нэмэгдэл	54,742,800.00	67,095,800.00
Унаа хоолны хөнгөлөлт	16,465,200.00	16,465,200.00
Урамшуулал		4,612,008.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,896,200.00	53,671,461.00
Тэтгэврийн даатгал	33,024,854.54	35,978,600.00
Тэтгэмжийн даатгал	4,717,836.35	4,423,100.00
ҮОМШӨ-ний даатгал	9,435,672.72	3,538,600.00
Ажилгүйдлийн даатгал	943,567.28	884,700.00
Эрүүл мэндийн даатгал	3,774,269.11	8,846,461.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	606,961.00	737,100.00
Гэрэл цахилгааны зардал	606,961.00	737,100.00
Хангамж, бараа материалын зардал	24,169,627.00	21,443,683.00
Бичиг хэрэг	10,064,000.00	4,441,600.00
Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,585,827.00	1,440,083.00
Ном, хэвлэл	11,149,800.00	14,278,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	84,000.00
Норматив зардал	550,000.00	7,550,000.00

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл		7,000,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	550,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	17,200,000.00	12,727,000.00
Багаж, техник, хэрэгсэл		
Тавилга		
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,200,000.00	12,727,000.00
Урсгал засвар		
Томилолт, зочны зардал	85,960,000.00	32,573,620.00
Гадаад албан томилолт		
Дотоод албан томилолт	85,960,000.00	32,573,620.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	245,297,180.00	178,932,487.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	243,330,314.00	175,911,897.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	2,000,000.00
Даатгалын үйлчилгээ	71,280.00	71,280.00
Тээврийн хэрэгслийн татвар	160,570.00	160,500.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246,400.00	246,400.00
Газрын төлбөр	466,616.00	520,410.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,500,000.00	1,938,531.00
Бусад урсгал шилжүүлэг	13,500,000.00	
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	13,500,000.00	
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,938,531.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
Төвлөрүүлэх шилжүүлэг		1,938,531.00
Хөрөнгийн		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>51,665,221.00</u>	<u>10,389,400.00</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	51,647,880.00	10,389,400.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	51,647,880.00	10,389,400.00
Дотоод эх үүсвэрээр	51,647,880.00	10,389,400.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	51,647,880.00	10,389,400.00
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>-51,647,880.00</u>	<u>-10,389,400.00</u>
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	17,341.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	240,151,898.93	13,518,156.31	453,700,558.1	707,370,613.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Тайлант үеийн үр дүн			99,271,911.58	99,271,911.58
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,151,898.93	13,518,156.31	552,972,469.59	806,642,524.83
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,151,893.93	13,518,156.31	552,972,469.59	806,642,524.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн		65,885,858.75		65,885,858.75
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн	323,512,960.00		86,227,616.44	409,740,576.44
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	563,664,858.93	79,404,015.06	639,200,086.03	1,282,268,960.02

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	650,069,500.00	646,886,553.00	3,182,947.00	99.5
УРСГАЛ ЗАРДАЛ	650,069,500.00	646,886,553.00	3,182,947.00	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	650,069,500.00	646,886,553.00	3,182,947.00	99.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	445,926,300.00	443,698,618.00	2,227,682.00	99.5
Үндсэн цалин	357,558,600.00	355,525,610.00	2,032,990.00	99.4
Нэмэгдэл	67,095,800.00	67,095,800.00		100
Унаа хоолны хөнгөлөлт	16,465,200.00	16,465,200.00		100
Урамшуулал	4,806,700.00	4,612,008.00	194,692.00	95.9
Гэрээт ажлын хөлс				
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,350,100.00	53,350,061.00	39.00	100
Тэтгэврийн даатгал	35,657,200.00	35,657,200.00		100
Тэтгэмжийн даатгал	4,423,100.00	4,423,100.00		100
ҮОМШӨ-ний даатгал	3,538,600.00	3,538,600.00		100
Ажилгүйдлийн даатгал	884,700.00	884,700.00		100
Эрүүл мэндийн даатгал	8,846,500.00	8,846,461.00	39.00	100
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	737,100.00	737,100.00		100
Гэрэл цахилгааны зардал	737,100.00	737,100.00		100
Хангамж, бараа материалын зардал	3,630,000.00	3,626,583.00	3,417.00	99.9
Бичиг хэрэг	300,000.00	760,000.00	(460,000.00)	253.3
Тээвэр, шатахуун	1,200,000.00	1,200,000.00		100
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,560,000.00	1,440,083.00	119,917.00	92.3
Ном, хэвлэл	400,000.00	142,500.00	257,500.00	35.6
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	170,000.00	84,000.00	86,000.00	49.4
Нормативт зардал	7,550,000.00	7,550,000.00		100
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,000,000.00	7,000,000.00		100
Нормын хувцас, зөөлөн эдлэл	550,000.00	550,000.00		100
Томилолт, зочны зардал	5,500,000.00	5,492,650.00	7,350.00	99.9
Гадаад албан томилолт				
Дотоод албан томилолт	5,500,000.00	5,492,650.00	7,350.00	99.9
Зочин төлөөлөгч хүлээн авах				

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,376,000.00	132,431,541.00	944,459.00	99.3
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,452,500.00	129,410,951.00	41,549.00	100
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,000,000.00	500,000.00	80
Даатгалын үйлчилгээ	71,300.00	71,280.00	20.00	100
Тээврийн хэрэгслийн татвар	163,200.00	160,500.00	2,700.00	98.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00		100
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	246,400.00	246,400.00		100
Газрын төлбөр	920,600.00	520,410.00	400,190.00	56.5
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	650,069,500.00	646,886,553.00	3,182,947.00	99.5
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	646,919,500.00	644,986,553.00	1,932,947.00	99.7
Улсын төсвөөс санхүүжих	646,919,500.00	644,986,553.00	1,932,947.00	99.7
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,150,000.00	1,900,000.00	1,250,000.00	60.3
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,150,000.00	1,900,000.00	1,250,000.00	60.3
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
Төсвийн байгууллага				
Төсвөөс гадуур байгууллага				
АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45		
Удирдах ажилтан	1	1		
Гүйцэтгэх ажилтан	39	39		
Үйлчлэх ажилтан	5	5		
Гэрээт ажилтан				

4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		117,515,416.00	- 117,515,416.00	
УРСГАЛ ЗАРДАЛ		117,515,416.00	- 117,515,416.00	
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		117,515,416.00	- 117,515,416.00	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,678,600.00	- 2,678,600.00	
Үндсэн цалин		2,678,600.00	- 2,678,600.00	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		321,400.00	- 321,400.00	
Тэтгэврийн даатгал			-	
Тэтгэмжийн даатгал			-	
ҮОМШӨ-ний даатгал			-	
Ажилгүйдлийн даатгал			-	
Эрүүл мэндийн даатгал			-	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал			-	
Гэрэл, цахилгаан			-	
Түлш, халаалт			-	
Цэвэр, бохир ус			-	
Байрны түрээс			-	
Тэтгэврийн даатгал		321,400.00	- 321,400.00	
Хангамж, бараа материалын зардал		17,817,100.00	- 17,817,100.00	
Бичиг хэрэг		3,681,600.00	- 3,681,600.00	
Ном, хэвлэл		14,135,500.00	- 14,135,500.00	
Эд хогшил худалдан авах		12,727,000.00	- 12,727,000.00	
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		12,727,000.00	- 12,727,000.00	
Томилолт, зочны зардал		27,080,970.00	- 27,080,970.00	
Гадаад албан томилолт			-	
Дотоод албан томилолт		27,080,970.00	- 27,080,970.00	
Зочин төлөөлөгч хүлээн авах			-	

Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		56,890,346.00	56,890,346.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		56,890,346.00	56,890,346.00	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		117,515,416.00	117,515,416.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого		117,515,416.00	117,515,416.00	-
Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан ЗГ хоорондын гэрээ болон ОУбайгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		24,540,000.00	24,540,000.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		92,975,416.00	92,975,416.00	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		-
Төсвийн байгууллага				-
Төсвөөс гадуур байгууллага				-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45		-
Удирдах ажилтан	1	1		-
Гүйцэтгэх ажилтан	39	39		-
Үйлчлэх ажилтан	5	5		-
Гэрээт ажилтан				-

4.7 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:

2019.02.22

Аудитын
нэр:

“Ургамал хамгааллын эрдэм
шинжилгээний хүрээлэн”-ын 2018
оны жилийн эцсийн санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудит

Аудитын код:

САГ-2019/40/СТА-ТШЗ

Шалгагдсан
байгууллагын нэр:

“Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний
хүрээлэн”

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	ХХОАТ шинэчилсэн хуулийн дагуу ажиллагсдын цалингаас татварын хөнгөлөлтийг тооцохдоо 691.3 мянган төгрөгөөр хөнгөлөлтийг илүү тооцсон зөрүү гарч байна.	691.3	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Бямбасүрэн
2	Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1,250.0 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн	1,250.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	М.Бямбасүрэн
	Нийт дүн	1941.3			

[illegible]